



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 116,991,050.00 (нэг зуун арван зургаан сая есөн зуун ерэн нэгэн мянга тавин) төгрөгийн балансын үнэ, 27,514,567.00 (хорин долоон сая таван зуун арван дөрвөн мянга таван зуун жаран долоон) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөр, Мэргэжлийн хяналтын газрын дарга Н.Цагаанхүү, Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны дарга Б.Отгонцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ГАНБАТ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



0000045

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 01 дүгээр сарын 22 -ны өдрийн
№ 7 дугаар тогтоолын хавсралт



**"МИАТ" төрийн өмчит хувьцаат компанийн балансаас
Буянт-Ухаа боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны балансад шилжүүлэх хөрөнгө**

Д/д	Автомашинны төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтанд орсон он	Нийт гүйлт /км/	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Автобус Jianghuai", суудлын, 19-64 УНЗ	2017	10557	116,991,050.00	27,514,567.00	89,476,483.00
				116,991,050.00 (нэг зуун арван зургаан сая есөн зуун ерэн нэгэн мянга тавин)	27,514,567.00 (хорин долоон сая таван зуун арван дөрвөн мянга таван зуун жаран долоон)	89,476,483.00 (наян есөн сая дөрвөн зуун далан зургаан мянга дөрвөн зуун наян гурван)
				НИЙТ ДҮН:		